



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн нээлттэй
дуудлагын худалдааг дахин
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн харьяа Архангай, Дорнод аймаг дахь Шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 2 автомашины 3 дахь удаагийн дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Автомашины худалдах шинэчилсэн доод үнийг хавсралтаар тогтоосугай.

3. Архангай аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга Ц.Эрдэнэцогт, Дорнод аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга Ц.Мөнхсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

000255

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
 179 дугаар тогтоолын хавсралт



НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ХАЙСААН

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Явсан км	Балансын үнэ (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨХ-ны 2015 оны 41 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ 50%-иар бууруулж (тогтоосон)
Архангай аймгийн Шүүхийн Тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин							
1	Суудлын автомашин, Тобота Градо 95.56-66 АРА, арал RZJ950016003	1998/2008	172,814	20,210,000.00	0	10,000,000.00	5,000,000.00
Дорнод аймгийн Шүүхийн Тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин							
2	Суудлын автомашин, Мицубуши Пажеро ММС, 00-27 ДОО, арал V434104079	1995/2008	159,972	14,100,000.00	0	2,500,000.00	1,250,000.00
Нийт дүн				34,310,000.00	-	12,500,000.00	6,250,000.00
				(гучин дөрвөн сая гурван зүүн арван мянга)	(арван хоёр сая таван зүүн мянга)		(зургаан сая хоёр зүүн тавин мянга)